


“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2025 оны 6 дугаар сарын 16

Ховд

Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Арга хэмжээ зохион байгуулах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ХЭГ/1122 дугаар албан бичгийн дагуу “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээг 2025 оны 5 дугаар сарын 19-23-ний өдрүүдэд зохион байгуулж дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах, долоо хоногийн арга хэмжээ зохион байгуулах талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-ын албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэв.



Ховд аймаг 2025 оныг баялаг бүтээгчдийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан “Ховдын бизнес 7 хоног” арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 19-23-ний өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд Ховдын бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал хэлэлцүүлэг, Ховд 2025 үзэсгэлэн худалдаа, Ховдын бизнес эрхлэгчид - 2025 зөвлөгөөн, Мэргэжилтэй ажилтан Ховдын баялаг хөдөлмөрийн өдөрлөг, Старт ап гарааны бизнес арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээг нээлттэй засгийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийн олон нийтийн оролцоо дэд сэдэвтэй уялдуулан зохион байгуулсан болно.

“Баялаг бүтээгч Ховд-2025” бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн нутгийн удирдлагын ордны хуралдааны их танхимд 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав.



Тус зөвлөгөөнд 17 сумын баялаг бүтээгчдийн төлөөлөл 250 орчим хүн оролцож тодорхой сэдвийн хүрээнд илтгэл, мэдээлэл тавьж, бизнес эрхлэгчдэд туршлага, шинэ санаа, мэдлэг олгосноороо ач холбогдолтой байлаа.




Сонгуулийн ерөнхий хороотой хамтран “Нээлттэй засгийн сорилт: улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” арга хэмжээг 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд аймгийн Ардчилсан нам, Монгол ардын намын санхүү хариуцсан ажилтнууд, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлийг оролцуулан СЕХ-оос ирүүлсэн видеог үзүүлж, холбогдох мэдээллийг өгөв.



“Нээлттэй засгийн түншлэл долоо хоног- 2025” арга хэмжээний хөтөлбөрийн дагуу пүрэв гаригт НҮБХХ-тэй хамтран зохион байгуулагдсан цахим сургалтанд аймгийн ИТХ-ын дарга З.Эрхбаяр, ЗДТГ-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Баасанхүү, БОНХОБТХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анхбаяр, ТЗУХ-ийн сум, байгууллагын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн З.Уянга, БОНХОБТХ-ийн Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Сүрэнжав, Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн Э.Даваадалай, Хууль эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн Ц.Болор-эрдэнэ нар хамрагдлаа.



Мөн арга хэмжээний хүрээнд нээлттэй засгийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийн нэг болох авилгаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээний хүнд суртал чирэгдлийг арилгах чиглэлээр контент бэлтгэн иргэдэд сошиалаар хүргэж, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.



ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БААСАНХҮҮ

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭСЭН:
СУМ, БАЙГУУЛЛАГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН З.УЯНГА

